

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2024 оны 06 дугаар сарын мэдээ

2024.06.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр:

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 15 албан бичиг ирсний 5 нь хариутай, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй болно.

Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах биеийн тамир спортыг хөгжүүлэх зорилгоор ахмадын хороонд нумт харвааны бууг худалдан авч дэмжлэг үзүүллээ.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр “Нарны Хаан хүүхдүүд” фестивалийг зохион байгуулж үйл ажиллагааны үеэр тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг төв замуудад хязгаарлалт хийсэн.

Сумын ОНХСангийн 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн гадна тоглоомын талбайг засварлаж хүүхдүүд амралтаараа чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж бүрдүүлэн ажиллаа.

Эрүүл мэндийн төвд шаардлагатай Зүрхний дифибриллятор тоног төхөөрөмжийг сумын ОНХСангийн 5,300,000 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авч Эрүүл мэндийн төвд хүлээлгэн өгсөн.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг бүрэн орж хуваарилсан. Байгууллагуудын тогтмол зардлыг хуваарийн дагуу олгосон. Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа. Статистикийн мал эмнэлгийн мэдээ, зоогийн газрын мэдээ, үнийн мэдээ, аж үйлдвэрийн мэдээ, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн судалгаа, амьдрах орчин аюулгүй байдлын судалгааг гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Сар бүр орон нутгийн ерөнхий орлогыг тухай бүрд холбогдох данс руу хааж бичилтийг хийж гүйцэтгэж байна. Төрийн сангийн цахим гүйлгээний систем санхүүгийн гүйлгээг тухай бүрд шивж цахимаар илгээж байна.

Хагас жилийн мал тооллого, хаягийн тодруулга зэрэг мэдээ тайланг цаг хугацаанд статистикийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. Төрийн аудит газарт санхүүгийн тайлан гаргалтын судалгаа, статистикийн хэлтэст малын хорогдлын судалгаа зэргийг гаргаж хүргүүлсэн.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн, ИТХ-ын ажлын албатай хамтран ЕБСургуулийн дотуур байрын ахлах ангийн сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг зохион байгууллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэг-1148, Урьдчилан сэргийлэх үзлэг-893, Алсын дуудлага, Гэрийн дуудлага-16, Гэрийн эргэлт-8, Идэвхтэй хяналт-74, Рентген зураг авалт-23, Өдрийн эмчилгээнд-6, Сэргээн засах эмчилгээ-43 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Эрүүл мэндийн газраас нийгмийн эрүүл мэндийн хууль суртачилах, сүрьеэ эдгэрдэг өвчин, олон найрлагт бичил тэжээлийн бэлдмэл, дархлаажуулалтын талаар сургалт зохион байгуулж, 5 мэргэжилтэн ирж зөвлөн тусалж, мэдээлэл арга зүйгээр хангалаа.

Багийн эмч нар тус бүрдээ багуудаар 2 удаагийн тойролт хийж халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх үзлэг болон хүүхдүүдэд А, Д аминдэм олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл тараасан.

Нийт хөдөөгийн 5 багийн 545 хүнд халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн ба 123 хүүхдэд А, Д аминдэм болон олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл тараасан.

Эрүүл мэндийн төвийн дарга, дүрс оношилгооны нарийн мэргэжлийн эмч Ц.Жигмэдсүрэн, дотрын нарийн мэргэжлийн их эмч Д.Аззаяа, Эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмч Б.Өлзий-Орших, их эмч М.Бүжин, бага эмч М.Ганзориг, 2 багийн дарга нартай хамтран 2 багт байгаа хөдөөгийн алслагдсан айл өрхөөр явж халдварт бус өвчин, в, с вирус, мобайл эхо, мобайл экг, үзлэг оношилгоо хийж А Д аминдэм тарааж, Олон найрлагат бичил бэлдмэлийн хяналт хийсэн.

Олон найрлагатай бичил тэжээлийг нийт 110 хүүхдэд тараасан. Д витаминг 80 хүүхдэд тарааж хэрэглээний хуудсыг тэмдэглэн ажиллаж байна.

6 сартайгаас-1 хүртэл насны 40 хүүхэд, 1-5 хүртэлх насны 370 хүүхэд А амин дэмд хамрагдсан байна.

Сумын төвөөс алслагдсан Дөхөм болон Дэлгэр багийн айл өрхөөр суурь тойрч халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх үзлэгийн үеэр 122 даатгалгүй иргэдийг эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамруулсан байна. Зорилтод бүлгийн 8 иргэнд В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад хамруулж, элэгний В С вирусийн архаг хүндрэлийн талаар мэдээлэл өгсөн. Ротари сангийн дэмжлэгтэй 15-19 насны нийт 184 хүүхдэд элэгний в с вирус илрүүлэх шинжилгээг хийсэн. Үүнээс 1 хүүхэд в вирустэй гарсан. Халдвартай хог хаягдлыг устгах автоклавыг байршуулж өрөө тасалгааг бэлтгэж засвар үйлчилгээ хийсэн. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд эмнэлгийн болон сувиллын хашаанд нийт 130 ширхэг мод тарьсан.

Ерөнхий боловсролын сургууль: "НАРНЫ ХААН ХҮҮХДҮҮД" өдөрлөг. Бага ангийн сурагчид болон дугуйлан секцийн сурагчид үзүүлбэр үзүүлж, эцэг эх, багш сурагчдад баярын мэндчилгээ дэвшүүлэв. СУМЫН ЗДТГ-ын журмын дагуух шагнал гардуулах" ёслолын ажиллагааны үеэр энэ хичээлийн жилд сурлага, урлаг спортоор онцлох амжилт гаргасан багш сурагчдад хүндэтгэл үзүүлж "Батламж, мөнгөн шагналаар урамшуулав.

Энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан Б.Баянтөр захирагчтай ...дугаар тусгай ротын хамт олноос волейболын шүүгчийн тавцан хүлээлгэн өглөө.

Сүхбаатар аймгийн бага боловсролын зөвлөх зэрэгтэй багш нарын МХБ-ээс уламжлан болгон зохион явуулдаг "Уншъя -Сэтгэе-Хөгжье" Монгол хэлний массын уралдаанд амжилтаа ахиулж 3-р ангийн 49 бүлгээс "Хурдан Уншлага" чадварын төрөлд

За анги "Тэргүүн " байр "Ойлгон унших" чадварын төрөлд 3-р байр тус тус эзэлсэн. Эрдмийн баярын тайлант өдөрлөгөөрөө 12Б ангийн сурагч Г.Одмаа, А.Сүндэръяа нар "Он цаг" бие даасан хамтарсан гар зургийн үзэсгэлэнгээ гаргаж танилцууллаа. Бага, дунд, ахлахын багш нар 2023-2024 оны хичээлийн жилийн "Багшийн хөгжлийн төлөвлөгөө"-ний дагуу хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж, ахиц амжилтаа хэлэлцэн, өөр өөрийн ажлын өвөрмөц онцлог арга зүйг бусдадаа түгээн дэлгэрүүлээ.

ОХУ-ын Красноярск хотод болсон С.Н.Баженовын нэрэмжит Жүдо бөхийн олон улсын тэмцээний +63кг жинд 7а ангийн сурагч Даваажаргалын Ану-дарь мөнгөн медаль хүртэж,бахдам амжилтын эзэн боллоо. Сүхбаатар аймгийн "Математикт Массараа Суралцъя" математикийн хичээлийн массын уралдаанд Алтанцэцэг багшийн хичээл заадаг 11а анги 3-р байр эзэллээ.

Хүүхдийн цэцэрлэг: Багш, ажилчид урсгал засварын ажлыг хийж, 2 ангийн сангийн холболтыг шинэчлэн бүрэн засварлаж дууслаа.

Хөдөөгийн 2 багт зуны сургалт хичээллүүлж байна. Үүнд нийт 45 хүүхэд хамруулж байна. Явуулын багшийн үйлчилгээгээр 4 багийн 23 хүүхдэд ном, тоглоомын багцыг хүргээд байна.

Соёл: Соёлын төвийн дэргэдэх "Мөрөөдөл бид хоёр" дууны дугуйлангийн сурагчдын эх үрсийн баярт зориулж " Нарны хаан хүүхдүүд" баярын тоглолтыг зохион явууллаа. Сумын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "Бүсгүй та хүн цэцэг" хүндэтгэлийн үйл ажиллагааг хамтран зохион явууллаа. Ахмадын хороотой хамтран "Одонтой ээж одонгийн хүүхэд" хамтдаа үйл ажиллагааг зохион явууллаа. "Энэ жилдээ эрүүл жиндээ-2" аяны хүрээнд нийтийн бүжиг 3 удаа зохион байгуулагдлаа.Үндэсний номын сангаас зохион байгуулсан КОХА системийн онлайн сургалтад хамрагдлаа. Номын сангийн Lib4Упрограммд 3460 ном оруулаад байна

"Бүх нийтийн соёлын боловсрол"-ийн хөтөлбөрийн хүрээнд Дарьганга нутгийн ард түмний дунд яригдаж өнөөг хүртэл уламжлагдан, судлагдаж тэмдэглэгдэн үлдээсэн үлгэрүүд болон урьд өмнө нь шинжилгээ судалгаанд хамрагдаагүй ард түмний оюун ухаан цээжинд хадгалагдан үлдсэн эртний сайхан үлгэрүүдийг сэргээн авч үлдэх, үлгэрээр дамжуулан хүүхэд багачуудыг хүмүүжүүлэх, тэдэнд соёл гоо зүйн боловсрол олгох, гэрийн хүмүүжлийг сэргээх, соёлын биет бус өвийг олон нийтэд сурталчлах түгээн дэлгэрүүлэх өвлөн уламжлагчдыг нээн илрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй Үлгэрийн наадмын 1-р шатыг сумандаа зохион байгуулж үлгэрч эмээ өвөө төрөлд 10, аав ээж төрөлд 2, ах эгч төрөлд 6 үлгэрч оролцож шилдэг үлгэрчдийг шалгарууллаа.

Үлгэрч Сүхбаатарчууд соёлын боловсролын хөтөлбөрийн хүрээнд Соёл урлагийн газраас зохион байгуулж байгаа "Дарьганга нутгийн үлгэрч эмээ өвөө, аав ээж, ах эгч" уралдааны 2-р шатанд 3 насны ангилалд үлгэрчдийг бэлтгэн оролцуулж үлгэрч эмээ өвөө, аав ээж төрөлд оролцсон 2 үлгэрч тэргүүн байр ах эгчийн төрөлд оролцсон үлгэрч гутгаар байр эзэллээ.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Монгол тарваганы нутаг дэвсгэрт Байгаль хамгаалагч, БОХУБ, Идэвхтэн байгаль хамгаалагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нийт 3 удаагийн давтамжтай Замын шанд ууланд, Нарийны дээд эх, Тарган эх, Баруун, Зүүн салаа гэсэн газруудад хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. Идэвхтэн байгаль хамгаалагч нар өдөр тутмын үйл ажиллагаандаа монгол тарваганы тоо толгойд анхаарал тавин ажиллаж байна. Нийт 210 гаруй тоологдож үүнээс 46 мөндлийг дурангаар болон нүдээр харах аргаар тооллоо.

Монгол тарвага тархсан нутгуудаар хяналт шалгалт хийсний үр дүнд тоо толгойн хорогдолгүй байна. Мөн идэвхтэн байгаль хамгаалагч нарын тусламжтайгаар өдөр тутамд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна. 3 удаагийн хяналт шалгалтын бензин шатах тосох материалын зардал 364 500 төгрөгийг зарцуулсан.

Олон нийтийн сүлжээ буюу Баяндэлгэр сумын ЗДТГ-ын мэдээллийн группт 21 удаагийн мэдээ мэдээллийг тухай бүр тавьж иргэдэд хүргэж ажилласан Нийт 783 хандалт авсан.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас “Ногоон орчин” түр ажлын байранд 10 иргэн ханган ажиллаж 3.600.000 төгрөгөөр цалинжуулан ажилласан. Мөн Байгаль хамгаалах сангаас 5 иргэнийг түр ажлын байраар ханган ажиллаж байна.

Хөдөө аж ахуй: Хагас жилийн мал тооллого болсонтой холбогдуулан сумын нийт хорогдсон мал, төлийн мэдээг өрх бүрээр нэгтгэж, ХХААГазар болон статистикийн хэлтэст хүргүүлээ.

Үүнд: том малын хорогдол нийт малын 60% буюу 277590 толгой мал хорогдож, адуу-7414, үхэр – 12512, тэмээ – 44, хонь – 163104, ямаа – 94516

Төллөсөн мал нийт 18572 хээлтэгч үүнд: ботго 94, унага 966, тугал 746, хурга 14141, ишиг 2625

Мөн 50-100% -ийн хорогдолтой 888 өрх, огт малгүй болсон 64 өрхийн судалгааг ХХААГазарт хүргүүлж ажиллалаа.

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 6 хоршоо байгуулагдаж зээлийн хүсэлтийг банканд хүргүүлж 1 хоршоо 55,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч 5 хоршоо банканд зээлээ судлуулж байна. Мөн өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан 1 хоршоо зээлийн хүсэлтээ банканд судлуулж байна.

Хавар тариалалт эхэлж 1,7 га талбайд төмс, 1,149 га талбайд хүнсний ногоо тариаллаа.